

## **ЕРӨНХИЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "Хууль" гэх)-ийн 8 дугаар зүйлийн 8.11 дэх хэсэгт заасан ерөнхий гэрээ байгуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Захиалагч ерөнхий гэрээ байгуулан бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

### **Хоёр. Нэр томьёо**

2.1. Энэхүү журамд заасан нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

2.1.1. “Захиалагч” гэж хуулийн 4.1-д заасныг;

2.1.2. “Мэргэжлийн байгууллага” гэж хуулийн 53.1-д заасан үүрэг бүхий Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг;

2.1.3. “Ерөнхий гэрээ” гэж хуулийн 5.1.23-т заасныг;

2.1.4. “Цахим дэлгүүр” гэж Ерөнхий гэрээнд үндэслэн бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл бүхий Цахим худалдан авах ажиллагааны системийн бүрэлдэхүүн хэсгийг;

2.1.5. “Ерөнхий гэрээний талууд” гэж Мэргэжлийн байгууллага, худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт бүртгэгдсэн нийлүүлэгч гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчийг;

2.1.6. “Шууд сонголт” гэж захиалагч цахим дэлгүүрийн санд бүртгэгдсэн бараа, ажил, үйлчилгээнээс худалдан авах тоо хэмжээ, хүргэх газар нь тодорхой тохиолдолд сонголт хийхийг;

2.1.7. “Цахим үнэ хаялцуулах” гэж Ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчийн тендерийн үнийг хамгийн бага үнийн дүнгээр нь автоматаар эрэмбэлэх;

2.1.8. “Үнийн санал авах” гэж худалдан авах ажиллагааны цахим систем дэх цахим дэлгүүрт бүртгэгдсэн нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчдээс ерөнхий гэрээний дагуу байгуулах гэрээний хүргэх газар, тоо хэмжээ, хамрах хүрээнд эцсийн үнийг хүлээн авахыг;

2.1.9. “Худалдан авалтын захиалга” гэж ерөнхий гэрээний дагуу худалдан авах захиалагчийн тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээг;

2.1.10. “Захиалгын хуудас” гэж цахим дэлгүүрээс худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, ажил гүйцэтгэх хуваарийг;

### **Гурав. Ерөнхий Гэрээ**

- 3.1. Ерөнхий гэрээг нэг буюу түүнээс дээш нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй хийнэ.
- 3.2. Ерөнхий гэрээний хүчинтэй хугацаанд түүний шалгуур шаардлагыг хангасан аливаа нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчийн хувьд нэмж оролцох эрх нь нээлттэй байна. Нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчдийн тоог хязгаарлахгүй.
- 3.3. Ерөнхий гэрээгээр бараа, үйлчилгээ худалдан авахдаа зөвхөн цахим дэлгүүрт бүртгэгдэж, ерөнхий гэрээнд нэгдсэн нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулж худалдан авна.
- 3.4. Ерөнхий гэрээ байгуулах ажиллагаа нь дараах 2 шаттай байна.
  - 3.4.1. Нэгдүгээр шат: Ерөнхий гэрээ байгуулах тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шаардлага хангасан оролцогчтой гэрээ байгуулах
  - 3.4.2. Хоёрдугаар шат: Мэргэжлийн байгууллагатай ерөнхий гэрээ байгуулан цахим дэлгүүрт бүртгэгдсэн нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчдээс шууд сонголт, цахим үнэ хаялцуулах, үнийн санал авах аргын аль нэгийг сонгон гэрээ байгуулах.
- 3.5. Ерөнхий гэрээний дагуу хийгдэх аливаа гэрээ нь энэ журам болон ерөнхий гэрээний нөхцөл, шаардлагын дагуу хийгдэнэ.
- 3.6. Ерөнхий гэрээг энэхүү журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан холбогдох жишиг баримт бичгийн гэрээний нөхцөлөөр байгуулна.
- 3.7. Ерөнхий гэрээнд гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, хэрэгжих хугацаа, захиалгын нөхцөл, үнэ, ерөнхий гэрээний хоёрдугаар шатны гэрээ байгуулах үндсэн аргачлал болон бусад шаардлагуудаас гадна дараах зүйлсийг тусгана:
  - 3.7.1. Тухайн бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт, ажлын даалгавар
  - 3.7.2. Ажил, үйлчилгээ үзүүлэх, бараа нийлүүлэх газар
  - 3.7.3. Ерөнхий гэрээний дагуу худалдан авах тоо хэмжээ болон хүргэх газар;
- 3.8. Ерөнхий гэрээнд тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа шаардахгүй.
- 3.9. Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаа нь 3 хүртэл жил байна.
- 3.10. Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ байгуулах ажиллагааг захиалагч цахим хэлбэрээр явуулна.
- 3.11. Төрийн захиргааны төв болон Засгийн газрын агентлаг нь ерөнхий гэрээний захиалагч заавал байна.

### **Дөрөв. Мэргэжлийн байгууллагын үүрэг**

- 4.1. Хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэгт заасан худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тухайн төсвийн жилд ерөнхий гэрээ байгуулан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг нэгтгэн төсвийн асуудал эрхлэх төрийн захиргааны төв байгууллагад, улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 5 хоногийн дотор Засгийн газарт тус тус хүргүүлнэ.

4.2. Мэргэжлийн байгууллага нь энэхүү журмын 4.1-д заасан жагсаалтад багтсан бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг жагсаалт батлагдсан даруйд эхлүүлнэ.

4.3. Мэргэжлийн байгууллага ерөнхий гэрээг байгуулах, хэрэгжүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.3.1. Ерөнхий гэрээний жагсаалтад багтсан бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагчийн жилийн худалдан авалтын захиалгыг тооцох жишиг маягтыг боловсруулж Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлуулах;

4.3.2. Ерөнхий гэрээнд хамруулахаар төлөвлөж буй бараа, ажил, үйлчилгээний судалгааг энэхүү журмын 3 дугаар хавсралтаар батлагдсан журмын дагуу жил бүрийн 3 дугаар улиралд багтаан хийх;

4.3.3. Ерөнхий гэрээний дагуу худалдаж авах бараа, үйлчилгээний стандартчилсан техникийн тодорхойлолт, ажлын даалгавар мөн нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчийг сонгох шалгуур үзүүлэлтийг 4.3.2-т заасан судалгаанд үндэслэн боловсруулах;

4.3.4. Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацааг тогтоох;

4.3.5. Ерөнхий гэрээг боловсронгуй болгон сайжруулах санал боловсруулж, Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

4.3.6. Ерөнхий гэрээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлэх, нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчдийг сонгох, ерөнхий гэрээ байгуулах, ерөнхий гэрээ байгуулсан оролцогчдыг цахим дэлгүүрт байршуулах, ерөнхий гэрээний хоёрдугаар шатны худалдан авах ажиллагааг зохион байгуулах;

4.3.7. Ерөнхий гэрээний дагуу худалдан авалт хийх цахим дэлгүүрийг цахим худалдан авах ажиллагааны системд бий болгох, хэвийн ажиллах нөхцөлийг ханган системийг хөгжүүлэх;

4.3.8. Мэргэжлийн байгууллага ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчийн бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг цахим худалдан авах ажиллагааны системийн “Цахим дэлгүүр” хэсэгт байршуулах;

4.3.9. Ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих, захиалагч байгууллагаас бараа, ажил, үйлчилгээний чанарын шаардлага хангаагүй асуудлаар мэдээлэл ирүүлсэн тохиолдолд тухайн дутагдалыг залруулах арга хэмжээ авах;

4.3.10. Захиалагч бүрийн худалдан авалтын захиалгын дүн нь ерөнхий гэрээний дагуу хийсэн гэрээний тоо хэмжээтэй тохирч байгаа эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;

4.3.11. Шаардлагатай тохиолдолд гэрээнд хуулийн 40.4 дэх хэсэгт заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг хүчингүй болгох;

4.3.12. Ерөнхий гэрээний хэрэгжилт болон үр дүнгийн тайлангийн маягтыг боловсруулж, тус маягтын дагуу тайланг нэгтгэн улирал бүр Төсвийн

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, олон нийтэд цахим хэлбэрээр мэдээлэх;

4.3.13. Захиалагч, гүйцэтгэгч, нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч нарт зориулсан Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гарын авлагыг боловсруулж, Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

4.3.14. Захиалагч болон тендерт оролцогчийг ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны талаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, тэдэнд сургалт зохион байгуулах.

### **Тав. Захиалагчийн үүрэг**

5.1. Захиалагч ерөнхий гэрээ байгуулах хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.1.1. Энэхүү журмын 4.3.2-т заасны дагуу мэргэжлийн байгууллагаас хийх судалгаанд хэрэгцээт бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээг үндэслэлтэй тодорхойлж, мэргэжлийн байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 1-ны дотор хүргүүлэх;

5.1.2. Тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн ерөнхий гэрээний дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын захиалгыг бэлтгэж, мэргэжлийн байгууллагад улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор багтаан хүргүүлнэ.

5.1.3. Захиалагч ерөнхий гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа зөвхөн цахим дэлгүүрт бүртгэгдсэн нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй цахим дэлгүүрийн зааврын дагуу гэрээ байгуулна.

5.1.4. Худалдан авалтын захиалга хийх бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг батлагдсан эсэхийг шалгасан байх;

5.1.5. Захиалгын хуудаст заасан тоо хэмжээ нь шаардагдаж буй хэрэгцээг хангаж байгаа эсэхийг нягтлан, баталгаажуулсан байх;

5.1.6. Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ байгуулж, хүлээн авсан бараа, ажил, үйлчилгээг чанарын шаардлага хангаж байгаа эсэхийг магадлах, цахим дэлгүүрт үнэлгээ өгөх, холбогдох төлбөрийг саадгүй гүйцэтгэх;

5.1.7. Ерөнхий гэрээний дагуу байгуулсан худалдан авах гэрээний хэрэгжилт болон үр дүнг цахим худалдан авах ажиллагааны системд тухай бүр оруулах.

5.1.8. Бараа, ажил, үйлчилгээний эрэлт, техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт гарсан аливаа өөрчлөлтийг Мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд ерөнхий гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар саналаа хүргүүлэх.

5.1.9. Ерөнхий гэрээний хүрээнд гэрээ байгуулан гүйцэтгэсэн бараа, үйлчилгээний чанар, тоо хэмжээг шалган баталгаажуулж ямар нэгэн доголдол гарсан тохиолдолд мэргэжлийн байгууллагад даруй мэдэгдэх.

5.2. Ерөнхий гэрээ байгуулан худалдан авахаар тодорхойлсон бараа, ажил, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр эх сурвалжаас Захиалагч худалдан авахыг хориглоно.

5.3. Цахим дэлгүүрээс худалдан авалт хийхдээ энэхүү журмын 3.4.2-т заасан аргын аль нэгийг сонгон, худалдан авах гэрээ байгуулна.

5.4. Энэхүү журмын 3.11-д зааснаас бусад захиалагч ерөнхий гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээг худалдан авах хүсэлтээ мэргэжлийн байгууллагад гарган, ерөнхий гэрээний захиалагч болж болно.

5.5. Худалдан авалтын захиалгыг цахим хэлбэрээр Цахим дэлгүүрийн зааврын дагуу хийх;

### **Зургаа. Ерөнхий гэрээний тендер шалгаруулалт**

6.1. Ерөнхий гэрээ байгуулах тендер шалгаруулалтыг Мэргэжлийн байгууллага нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, цахим хэлбэрээр зохион байгуулна.

6.2. Ерөнхий гэрээ байгуулах тендерийн баримт бичиг болон бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахдаа захиалагчийн ирүүлсэн худалдан авалтын захиалгад үндэслэнэ.

6.3. Ерөнхий гэрээний тендерийн баримт бичиг нь тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, бүрдүүлэх шаардлагатай холбогдох баримт бичиг, чадварын жишиг маягт, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл зэргээс бүрдэнэ.

6.4. Ерөнхий гэрээг шаардлага хангасан бүх тендерт оролцогчтой байгуулна.

6.5. Мэргэжлийн байгууллага нь шаардлагад нийцсэн оролцогчдод гэрээ байгуулах эрх олгох эсхүл татгалзсан тохиолдолд үндэслэлийг нэн даруй мэдэгдэнэ.

6.6. Мэргэжлийн байгууллага үнэлгээний дүнг цахимаар байршуулах бөгөөд дараах мэдээллүүд багтсан байна.

6.6.1. Ерөнхий гэрээний оролцогчийн тендерийн үнэлгээний тухай мэдээлэл

6.6.2. Чадварын болон бусад шаардлагыг хангасан бүх тендерт оролцогчийн жагсаалт

6.6.3. Оролцогчийн ирүүлсэн санал нь ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолттой нийцсэн эсэх

6.6.4. Татгалзсан болон шаардлага хангаагүй оролцогчийн жагсаалт, татгалзсан үндэслэл

6.6.5. Ерөнхий гэрээ байгуулахаар шалгарсан бүх оролцогчийн танилцуулга, шалгарсан огноо, үнэлгээний дүгнэлтийн хураангуй

6.7. Мэргэжлийн байгууллага ерөнхий гэрээ байгуулахаар шалгарсан оролцогчийн жагсаалтыг гаргаж, мэдээлэх бөгөөд шалгарсан нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчдийг цахим дэлгүүр дэх гэрээний хамрах хүрээгээр эсхүл бараа, ажил, үйлчилгээний төрлөөр нь ангилалд оруулна.

## Долоо. Цахим дэлгүүр болон гэрээ байгуулах эрх олгох

- 7.1. Ерөнхий гэрээний дагуу хийгдэх худалдан авах гэрээ нь энэ журам болон ерөнхий гэрээний нөхцөл шаардлагын дагуу хийгдэнэ.
- 7.2. Цахим дэлгүүрийн санд бүртгэгдсэн бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар нь тодорхой эсхүл цахим дэлгүүрт нэг нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгч байгаа нөхцөлд захиалагч “шууд сонголт” аргыг хэрэглэнэ.
- 7.3. Энэ журмын 7.2-д зааснаас бусад нөхцөлд мэргэжлийн байгууллага энэ журмын 3.4.2-т заасан худалдан авах ажиллагааны хоёрдугаар шатны сонгон шалгаруулалт буюу “Цахим үнэ хаялцуулах”, “Үнийн санал авах ажиллагаа”-г захиалагчийн хүсэлтийн дагуу зохион байгуулна.
- 7.4. Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэгж үнийг бууруулах зорилгоор "цахим үнэ хаялцуулах" аргыг хэрэглэнэ.
- 7.5. Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газрыг эцэслэн тогтоож, үнийг тогтооход "үнийн санал авах" аргыг хэрэглэнэ.
- 7.6. Захиалагч цахим дэлгүүрээс худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт, тоо хэмжээ, хүргэх газрыг эцэслэн тогтоож, захиалгын хуудсыг цахим системд ирүүлнэ.
- 7.7. Цахим системд ирүүлсэн захиалгын хуудсыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан мэргэжлийн байгууллага хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, захиалагчийг ерөнхий гэрээний оролцогчтой гэрээ байгуулах нөхцөлөөр хангана.
- 7.8. Цахим үнэ хаялцуулах ажиллагаанд оролцох урилгыг тухайн ерөнхий гэрээ байгуулсан оролцогчид цахимаар мэдэгдэж, тухайн өдрөөс хойш ажлын 3 хүртэл хоногийн дараа цахим үнэ хаялцуулах ажиллагааг 2 цаг хүртэл хугацаагаар зохион байгуулна.
- 7.9. Цахим үнэ хаялцуулах ажиллагаанд хамгийн бага үнийн санал ирүүлсэн оролцогчтой захиалагч гэрээ байгуулна.
- 7.10. Үнийн санал авах ажиллагаанд оролцох урилгыг тухайн ерөнхий гэрээ байгуулсан оролцогчид цахимаар мэдэгдэж, үнийн санал авах хугацааг тухайн өдрөөс хойш ажлын 5 хүртэл хоногоор тогтооно.
- 7.11. Үнийн санал авах ажиллагаанд үнэ, ажлын хуваарь, бараа нийлүүлэлтийн хуваарь, хүргэлтийн нөхцөл зэргийг харгалзан үнийн санал ирүүлсэн оролцогчтой захиалагч гэрээ байгуулна.
- 7.12. Хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтын үед захиалагч техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт өөрчлөлт оруулах талаар ерөнхий гэрээнд тусгаснаас бусад тохиолдолд оролцогчоос шаардахыг хориглоно.
- 7.13. Ерөнхий гэрээ байгуулсан нэгж үнэ нь хуулийн 28.6-д заасан үнэ байна. Энэ үнэ нь тухайн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах хамгийн дээд үнийн хязгаар байна.
- 7.14. Цахим дэлгүүрт журмын 7.14-т заасан үнийг “нэгж үнэ”, “тээвэрлэлтийн зардлыг хассан нэгж үнэ” гэсэн хоёр сонголттойгоор байршуулна.

7.15. Энэ журмын 7.8-д заасан хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтанд нэг ч оролцогч саналаа ирүүлээгүй бол цахим дэлгүүрээс захиалагч шууд сонгон, гэрээ байгуулна.

7.16. Ерөнхий гэрээ байгуулах хүсэлтэй нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгч нь тухайн ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд ерөнхий гэрээ байгуулах хүсэлтийг бичгээр Мэргэжлийн байгууллагад ирүүлж болно.

7.17. Мэргэжлийн байгууллага ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд уг журмын 7.17-д заасан хүсэлтийг харгалзан шаардлагатай гэж үзвэл ерөнхий гэрээ байгуулах тендер шалгаруулалтыг жилд 2 удаа зохион байгуулж болно.

7.18. Мэргэжлийн байгууллага ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд шинээр ерөнхий гэрээ байгуулах тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа анх зарласан тендерийн баримт бичгийн дагуу явуулах бөгөөд тендер шалгаруулалтын шаардлагыг нэмэгдүүлэх эсхүл багасгахыг хориглоно.

7.19. Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд гэрээ шинээр байгуулсан оролцогчийн гэрээний хугацаа нь тухайн ерөнхий гэрээний үлдсэн хугацаагаар байгуулагдах бөгөөд гэрээний эрх, үүрэг нь мөн адил байна.

7.20. Мэргэжлийн байгууллага сонгон шалгаруулалт дууссан даруйд шинэ нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчийг цахим дэлгүүрт бүртгэнэ.

7.21. Ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгч нь чадварын шаардлагыг цаашид хангаж чадахгүй болсон бол мэргэжлийн байгууллагад нэн даруй буюу өөрчлөлт гарснаас хойш 7 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

### **Найм. Ерөнхий гэрээг өөрчлөх, түдгэлзүүлэх, цуцлах үндэслэл**

8.1. Мэргэжлийн байгууллага Ерөнхий гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй эсхүл гэрээ байгуулах үйл ажиллагаанд оролцох урилганд хариу ирүүлээгүй нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчийн эрхийг түдгэлзүүлж болно.

8.2. Дараахь тохиолдолд мэргэжлийн байгууллагын шийдвэрээр гэрээг цуцалж болно.

8.2.1. Хэрэв гэрээний хүчин төгөлдөр хугацаанд 3 буюу түүнээс дээш удаагийн худалдан авалтын захиалга хийхэд гүйцэтгэгч ажлын 5 хоногт хариу өгөөгүй;

8.2.2. Захиалагч байгууллага нь нийлүүлэгчтэй үгсэн хуйвалдсаныг эрх бүхий этгээд тогтоосон;

8.2.3. Нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, гүйцэтгэгч нь ерөнхий гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

8.2.4. Ерөнхий гэрээ нь бодитойгоор хэрэгжихгүй байгаа нь тогтоогдсон;

8.2.5. Гэрээнд заасан бусад.

8.3. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна.

ЕРӨНХИЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ  
ТЕНДЕРИЙН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ



## Ерөнхий гэрээнд хамруулах бараа, ажил, үйлчилгээний судалгаа

Худалдан авах ажиллагааны газар нь ерөнхий гэрээнд хамруулах барааг тодорхойлохдоо дараах судалгаануудыг хийж, түүний үр дүнд үндэслэн “Ерөнхий гэрээ байгуулах журам”-ын 3.1-д заасны дагуу саналаа нэгтгэн боловсруулж Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

1. Эрэлтийн судалгаа хийх
  - 1.1. Засгийн газрын нийт худалдан авалт буюу нийт эрэлт хэрэгцээг тодорхойлж, түүний ач холбогдлыг үнэлэх
  - 1.2. Дээрх эрэлт хэрэгцээтэй уялдуулан нийлүүлэлтийн талаар судалгаа хийж, үүсэж болзошгүй хүндрэл, бэрхшээлийг тооцох
  - 1.3. Ерөнхий гэрээнд хамруулах бараа, ажил, үйлчилгээний нэр, танилцуулга, техникийн тодорхойлолтыг гаргах
2. Оролцогч талуудын судалгаа
  - 2.1. Захиалагч бүрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох
  - 2.2. Нийлүүлэгч, гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчийн чадавхийг тодорхойлох
3. Зах зээлийн судалгаа
  - 3.1. Зах зээлийн бүтэц, өрсөлдөөний хэлбэр, хэмжээ, үнийн судалгаа
  - 3.2. Хувилбарт барааны сонголтын талаар судалгаа хийх
4. Тухайн бараа, ажил, үйлчилгээг ерөнхий гэрээ байгуулан худалдан авахад үүсэх нөхцөлийг тодорхойлох “SWOT” шинжилгээ хийх

	Хэрэгтэй (зорилгодоо хүрэхэд)	Эрсдэлтэй (зорилгодоо хүрэхэд)
Дотоод хүчин зүйл	Давуу тал	Сул тал
Гадаад хүчин зүйл	Боломж	Аюул, занал

5. Ерөнхий гэрээ байгуулахтай холбоотой Эрсдлүүдийг тодорхойлох, эрсдлээс сэргийлэх төлөвлөгөө гаргах.

<b>Эрсдэл</b>	<b>Боломж</b>	<b>Нөлөөлөл</b>	<b>Эрсдлыг арилгах, багасгах, хөнгөвчлөхөд шаардлагатай арга хэмжээ</b>

--o0o--